

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2005 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч нь: Ерөнхий шүүгч
С.Батдэлгэр

Эрхэм шүүгчид, албан хаагчид аа!

Улсын Дээд шүүх, түүний шүүгч, ажилтнууд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хараат бус байж, гагцхүү Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдан ажиллах зарчмыг баримтлан ажиллаж ирлээ.

Түүнчлэн “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”, “Шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал”-ыг ажил хэрэг болгох замаар шүүхийн шинэчлэлийг улам гүнзгийрүүлж, эрчимжүүлэхийн тулд нөөц бололцоо, хүч чармайлтаа дайчлан ажиллаа.

Тайлангийн хугацаанд шүүхийн шинэчлэлийн үйл ажиллагаанд АНУ-ын “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төсөл, Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл, ХБНГУ-ын “Ханнс-Зайделийн сан”, “Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг”, Япон Улсын “Жайка”, БНСУ-ын “Койка” зэрэг олон улсын байгууллагууд үнэтэй хувь нэмэр оруулж байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах зорилгоор Захиргааны болон Иргэний хэргийн шийдвэрийг товхимол ном болгон гаргасан явдал нь эрх зүйн онол, шүүхийн практик судлалыг хослуулан хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон гэж үзнэ.

Улиран өнгөрч буй **2005 он** нь Улсын Дээд шүүхийн хувьд ажлын ахиц дэвшил, дутагдал, бэрхшээлийн аль аль нь хосолсон жил байлаа.

Шүүгч, ажилтнууд албан үүргээ зохих ёсоор амжилттай биелүүлж байгааг Төр, засгаас өндрөөр үнэлж 2005 онд Монгол Улсын **Ерөнхийлөгчийн зарлигаар** Улсын Дээд шүүхийн шүүгч Ч.Ганбат, Б.Доржготов, С.Нямжав нар “**Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон**”-гоор;

Улсын Дээд шүүхийн шүүгч П.Цэцгээ “**Алтан гадас**” одонгоор;

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тогтоолоор Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан, Улсын Дээд шүүхийн шүүгч А.Доржготов нар “**Шүүхийн тэргүүний ажилтан**” цол, тэмдгээр;

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын захирамжаар Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа, шүүгч А.Доржготов, Б.Доржготов, Ч.Тунгалаг, П.Цэцгээ, Улсын Дээд шүүхийн дарга асан, Ахмадын зөвлөлийн гишүүн Х.Дамдин нар Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “**Хүндэт тэмдэг**”-ээр шагнагджээ.

Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар Улсын Дээд шүүхийн шүүгч Р.Жамъянчойжил, Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун, Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга Н.Төрбат, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга М.Дамирансүрэн нар “**Төрийн албаны зөвлөлийн тэргүүний ажилтан**”-аар;

Монголын Залуучуудын холбооны Ерөнхийлөгчийн тушаалаар Улсын Дээд шүүхийн шүүгч Ч.Ганбат, Цагаатгалын ажил хариуцсан шинжээч М.Чойням нар “**Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч**” медалиар, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах-шинжээч М.Алдар, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Ц.Оч нар “**Хөдөлмөрийн алдар**” алтан медалиар, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Д.Алтанжигүүр “**Тэргүүний залуу**” алтан медалиар тус тус шагнагджээ.

2005 онд С.Батдэлгэрийг Улсын Дээд шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Ц.Амарсайханыг Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүний, Д.Батсайханыг Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний, Л.Атарцэцэгийг Улсын Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсон Монгол Улсын **Ерөнхийлөгчийн зарлиг** гарлаа.

Түүнчлэн өндөр насны тэтгэвэрт гарах насанд хүрсэн Улсын Дээд шүүхийн шүүгч Н.Төрбат, М.Дамирансүрэн нарыг шүүгчийн албан тушаалаас нь чөлөөлсөн **Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг** гарсан байна.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цагдаагийн Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын дарга нарын **хамтарсан захирамж, тушаалаар “Шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийн тоо бүртгэлийг хөтлөх, лавлагаа олгох заавар”**-ыг батлан хэрэгжүүлж байна.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2005 оны 55 дугаар тогтоолоор Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн мэдээ, ялаас хугацааны өмнө тэнсэн сулласан тухай мэдээ, захиргааны арга хэмжээ авсан тухай мэдээний маягтуудыг тус тус шинэчлэн батлан мөрдүүлж эхэллээ.

“Өргөдөл гомдлын шийдвэрлэлт, шүүн таслах ажиллагааны тухай”, “Ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай”, “Ажлын зохион байгуулалт, харуул хамгаалалт, сонор сэрэмжийг дээшлүүлэх тухай” Ерөнхий шүүгчийн захирамж гарган нийт шүүхэд хүргүүллээ.

Түүнчлэн “Улсын Дээд шүүхэд албан хэрэг хөтлөх заавар”, “Улсын Дээд шүүхэд хэрэг болон, иргэд, хуулийн этгээд, хэргийн оролцогчдоос гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, хувиарлах, шийдвэрлэх журам”, “Иргэд, хуулийн этгээд, тэдгээрийн төлөөлөгчид, хэргийн оролцогчдыг хүлээн авах цагийн хуваарь”, “Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын зөвлөлийн ажиллах журам”, “Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн ажлын албаны зорилт, гүйцэтгэх үүргийн тодорхойлолт”, “Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны ажиллах журам”, “Архив, номын сан ажилуулах журам”, “Улсын Дээд шүүхийн албан ёсны хуулийн тайлбар, шүүхийн шийдвэрийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, ажлын хэсгийг шинэчлэн байгуулах, шүүхийн шийдвэрийг нийтлэх журам”-ыг Ерөнхий шүүгчийн захирамжаар шинэчлэн батлан гаргалаа.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын бүтэц, зохион байгуулалт, орон тоог Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2005 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар шинэчлэн баталж, Ерөнхий шүүгчийн ажлын алба, Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын алба, Санхүү, хангамж, үйлчигээний алба, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба, Шүүхийн судалгааны төв гэсэн 5 нэгжтэйгээр ажиллаж эхэллээ.

Улсын Дээд шүүх 2005 оны ажлын төлөвлөгөөндөө **5** бүлэг **80** ажлыг төлөвлөснөөс нь **64** ажил бүрэн биелэж, **14** ажил хойшлогдож, **2** ажил тасалдсан байна. Тухайлбал:

Эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаанд баримтлах “Нэгдсэн бодлого”-ын төсөл тодорхой бус шалтгаанаар Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэгдэж батлагдаагүй байна.

Харин хуулийн тайлбаруудын тухайд гэвэл “Патентийн тухай хууль” Улсын Их хурлаар шинэчлэгдэн батлагдахаар төсөл нь хэлэлцэгдэх гэж байгаа тул, “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн тайлбарыг иргэн, захиргааны хэргийн танхимын зөвлөлгөөнөөр хэлэлцээд тайлбарлах шаардлагагүй гэсэн хариуг албан бичгээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд өгсөн байна.

Түүнчлэн “Банкны тухай хууль”, “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль”, “Зээл тооцооны үүргийн тухай хууль”-ийн тайлбарын төсөл нь хийгдсэн боловч Иргэний хэргийн танхимын зөвлөгөөнөөр ирэх онд Нийт шүүгчдийн хуралданаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэжээ.

“Улс төрийн намуудын тухай хууль”, “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн тайлбарыг иргэний хэргийн танхимын зөвлөгөөнөөр хэлэлцээд хойшлуулсан, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн албан ёсны болон шинжлэх ухааны тайлбарын төслийг ажлын хэсгийнхэн нь хуулийг хэрэглээд тодорхой хугацаа өнгөрсний дараа гаргая гэж шийдвэрлэсэн тул хойшлогджээ.

“Иргэний хууль”, “Эрүүгийн хууль”, “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-ийн зарим зүйл заалтыг тайлбарлах асуудлыг уг хуулиудад нэмэлт өөрчлөлт орох гэж байгаатай холбогдуулан энэ жил хойшлууллаа.

Харин Газрын харилцаа, Геодези, зураг зүйн газартай хамтран ярилцлага зохион байгуулах ажил тухайн байгууллагаас шалтгаалж, Газрын тухай хуулийг шүүхийн практикт нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар зөвлөмж гаргах болон шүүгч ажилтнуудыг “**Байгалийн үзэсгэлэнт газар**”-аар аялуулах ажил тодорхой бус шалтгааны улмаас тасалдсан байна.

Эдгээр ажлыг шинэ онд хийж гүйцэтгэх талаар шүүгч, ажилтнууд анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзнэ.

Шүүгчдийн зөвлөлийн хуралдааныг 2005 оны 2 дугаар сарын 2, мөн оны 10 дугаар сарын 28-ны өдөр 2 удаа зарлан хуралдуулж, Шүүгчдийн зөвлөлөөс Шүүхийн Ерөнхий зөвлөл, Шүүхийн Мэргэшлийн болон Сахилгын хорооны гишүүнээр сонгох шүүгчдийн асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэв.

“Шүүх эрх мэдлийн шинэтгэл” хөтөлбөр төслийн санхүүгийн дэмжлэг туслалцаатайгаар “**Шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн төв**”-ийг байгуулахаар засварын ажлыг хийж дуусгаад байна.

“**Дээд Шүүхийн Мэдээлэл**” сэтгүүлийг нийтийн хэвлэл захиалгад оруулснаар уг сэтгүүлийг эрхлэн гаргах санхүүгийн эх үүсвэрийг олж, өөрсдийн хөрөнгөөр хэвлүүлж, бүх шатны шүүхийн шүүгчид болон бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулжээ.

Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн тусламжтайгаар “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ” байгуулах ажил явагдаж байна. Шүүхийн мэдээллийн системийн сүлжээний төв нь Улсын Дээд шүүхэд байрлах бөгөөд энэ төвтэй Нийслэлийн шүүх, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх, дүүргийн шүүхүүд шилэн кабелиар холбогдоно. Цаашид орон нутгийн шүүхүүдийг уг сүлжээнд зайлшгүй холбох шаардлагатай гэж үзнэ. Ингэснээр шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй хүрэх боломж бүрдэнэ.

“Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслийн санхүүгийн дэмжлэг туслалцаатайгаар “**Улсын Дээд шүүхийн Вэб сайт**”-ыг Интернетэд байрлуулах ажил дуусч байгаа бөгөөд “**Улсын Дээд шүүхийн 2004 оны жилийн ажлын тайлан**”-г ном болгон хэвлүүлж нийтийн хүртээл болголоо.

ХБНГУ-ын “**Ханнс–Зайдел**”-ийн сангийн санхүүгийн дэмжлэг туслалцаатайгаар Аймаг, нийслэл, нийслэлийн захиргааны хэргийн болон зарим сум буюу сум дунд, дүүргийн шүүхийн **Ерөнхий шүүгчдийн Нэгдсэн зөвлөгөөн** семинарыг 2005 оны 1 дүгээр сарын 31-нээс 2 дугаар сарын 2-ны хооронд Төр, засгийн үйлчилгээний “**Элит**” төвд зохион байгуулав.

Засгийн газрын 1996 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам”-ын дагуу бүх шүүгчид, тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдаас “**Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг**”-ийг **2004 оны** байдлаар гаргуулан авч, шүүгчдийн “Хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг Шүүхийн Ерөнхий зөвлөлд, харин ажилтнуудын “Хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын асуудал хариуцсан референтэд өгч хадгалуулж байна.

Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажиллагааны дүн мэдээ гарч, Танхимууд, Тамгын газар, Шүүхийн судалгааны төвийн тайлан гарлаа. Ингээд Дээд шүүхийн 2005 оны **Нэгдсэн тайланг** товч танилцуулъя.

Нэг. Шүүн таслах ажиллагааны талаар

Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдааныг 12 удаа зарлан, нийт 12 өдөр хуралдуулж, бүгд **52** асуудал хэлэлцэж, **42** тогтоол гаргасны дотор эрүүгийн хэрэг **31**, иргэний хэрэг **5**, захиргааны хэрэг **1**, аймгийн шүүхийг шалган тусалсан дүнгийн тухай мэдээлэл **6**, хуулийн тайлбар **3**, бусад **6** асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргав.

Өнгөрсөн жилтэй харьцуулахад Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдаан хийсэн өдөр **7**-гоор, хэлэлцсэн асуудлын тоо **20**-оор, эрүүгийн хэрэг **11**-ээр, иргэний хэрэг **2**-оор, захиргааны хэрэг **1**-ээр, аймгийн шүүхийг шалган тусалсан ажил **1**-ээр, хуулийн тайлбар **1**-ээр тус тус нэмэгджээ.

Эрүүгийн хэргийн танхим

Тус эрүүгийн хэргийн танхим нь **хяналтын журмаар** эрүүгийн **814**, цагаатгалын **64**, нийт **878** хэрэг хүлээн авч, түүний **94,6** хувь буюу эрүүгийн **768**, цагаатгалын **63** хэргийг хянаж шийдвэрлэжээ.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн Д.Батсайхан **220**, шүүгч С.Нямжав **195**, Б.Доржготов **167**, М.Дамирансүрэн **152**, Н.Төрбат **63** эрүүгийн хэрэг хүлээж авсан ба одоо **47** хэргийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **360**, шүүгч С.Нямжав **396**, Б.Доржготов **395**, Н.Төрбат **300**, М.Дамирансүрэн **278** удаа тус тус оролцсоноос;

Танхимын тэргүүн Д.Батсайхан **191**, шүүгч Н.Төрбат **295**, С.Нямжав **45** Б.Доржготов **41**, М.Дамирансүрэн **15** хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Ерөнхий шүүгч С.Батдэлгэр **2**, Танхимын тэргүүн Д.Батсайхан **117**, шүүгч С.Нямжав **162**, Б.Доржготов **136**, М.Дамирансүрэн **131**, шүүгч Н.Төрбат **39**, шүүгч Д.Пунцаг **7**, Танхимын тэргүүн О.Зандаа, шүүгч Л.Атарцэцэг, Ч.Тунгалаг, П.Цэцгээ нар тус тус **6 хэрэг илтгэсэн** байна.

Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **67** өдөр хуралдаж, **өдөрт 8-9** хэрэг хэлэлцэж, бүгд **618** хэрэг хянан шийдвэрлэсний **96.1** хувь буюу **594** нь эрүүгийн, **3,9** хувь буюу **24** нь цагаатгалын хэрэг байв.

Улсын Дээд шүүхийн **хяналтын шатны** эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн **594** эрүүгийн хэргийн **56,5** хувь буюу **336** тогтоол, магадлалыг **хэвээр үлдээж**, **17,3** хувь буюу **103** нь **өөрчлөгдөж**, **30,1** хувь буюу **179** тогтоол, магадлалыг **хүчингүй** болгожээ.

Өөрчлөгдсөн **103** тогтоол, магадлалын **5,8** хувь буюу **6** нь Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, **9,7** хувь буюу **10** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **10,6** хувь буюу **11** нь хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, **4,8** хувь буюу **5** нь хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн, **68,9** хувь буюу **71** нь шийтгэх тогтоол, магадлалд бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болсон **179** тогтоол, магадлалтай хэргээс **96** хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт, **57** хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, **26** хэргийг **хэрэгсэхгүй** болгосон байна.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн **24** цагаатгалын хэргийн **37,5** хувь буюу **9**-д нь хэлмэгдэгсдийн овог, нэрийг өөрчлөж, **54** хувь буюу **13** хүнд холбогдох хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон тэднийг цагаатгаж, **1** хүнд холбогдох хэргийг цагаатгах боломжгүй тул тогтоол, магадлалыг хэвээр үлдээжээ.

Улсын Дээд шүүхийн **Нийт шүүгчдийн** хуралдаанаар эрүүгийн **30** хэрэг хянан хэлцэгдсэний **6** нь Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр, **24** нь цаазаар авах ялтай хэрэг байв.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **81** хувь буюу **631** нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн гомдлоор, **15,5** хувь буюу **121** нь яллагчийн эсэргүүцлээр, **4,2** хувь буюу **33** нь прокурорын дүгнэлтээр хэлэлцэгджээ.

Тайлангийн хугацаанд Ерөнхий шүүгч С.Батдэлгэр **2**, Танхимын тэргүүн Д.Батсайхан **86**, шүүгч С.Нямжав **38**, Н.Төрбат **28**, М.Дамирансүрэн **25**, Б.Доржготов **19** хэргийг тус тус **хянаад буцаасан** байна.

Тус танхим 2005 онд нийт **279** өргөдөл, гомдол хүлээн авснаас Ерөнхий шүүгч С.Батдэлгэр **7**, Танхимын тэргүүн Д.Батсайхан **54**, шүүгч Б.Доржготов **43**, Н.Төрбат **76**, С.Нямжав **39**, М.Дамирансүрэн **60** өргөдлийг тус тус хянан шийдвэрлэж, одоо **13 өргөдлийн** үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны **иргэний** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **49**, шүүгч Н.Төрбат **15**, С.Нямжав **66**, Б.Доржготов **83**, М.Дамирансүрэн **19**, Захиргааны хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **39**, шүүгч С.Нямжав **48**, Б.Доржготов **53**, М.Дамирансүрэн **34**, Н.Төрбат **16** удаа тус тус оролцож, Танхимын тэргүүн Д.Батсайхан **9**, шүүгч Н.Төрбат **12** шүүх хуралдааныг даргалжээ.

Иргэний хэргийн танхим

Иргэний хэргийн танхимын шүүгчид иргэд, байгууллагаас нийт **174** өргөдөл, гомдол хүлээн авч, **166-г** нь буюу **95.4** хувийг шийдвэрлэжээ. Үүнд: Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **99**, шүүгч Р.Жамъянчойжил **49**, Д.Тунгалаг **10**, А.Доржготов **8-ыг** тус тус хянан шийдвэрлэж, одоо **8** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Энэ онд тус танхим өмнөх оны **38** хэргийн үлдэгдэл дээр **хяналтын журмаар** нийт **837** хэрэг шинээр хүлээн авч, иргэний **635** хэргийг **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй** хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, **112** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанд оруулах үндэслэлгүй учир **Ерөнхий шүүгчид** танилцуулан буцааж, **95** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж шийдвэрлэжээ. Одоо хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх **13** хэрэг, Ерөнхий шүүгчид дүгнэлт гаргуулахаар гомдол гаргасны дагуу хянагдаж байгаа **20** хэргийн үлдэгдэлтэй байна.

Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **287** хэрэг хүлээн авч, **273-г шийдвэрлэж**, үүнээс **216** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн;

Шүүгч А.Доржготов **247** хэрэг хүлээн авч, **245** хэргийг **шийдвэрлэж**, үүнээс **196** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн;

Шүүгч Д.Тунгалаг **241** хэрэг хүлээн авч, **234-г шийдвэрлэж**, үүнээс **197** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн;

Шүүгч Р.Жамъянчойжил **92** хэрэг хүлээн авч, **87-г шийдвэрлэж**, үүнээс **26** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн байна.

2005 онд Дээд шүүхийн **Иргэний хэргийн хяналтын** шатны шүүх хуралдаан **68** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **10** хэрэг хэлэлцэн, нийт **635** хэрэг шийдвэрлэжээ.

Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **624** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос**, **242** хуралдааныг **даргалж**;

Шүүгч Д.Тунгалаг **611** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос**, **26** хуралдаан **даргалж**;

Шүүгч А.Доржготов **610** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос**, **24** хуралдаан **даргалж**;

Шүүгч Р.Жамъянчойжил **377** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос**, **275** хуралдааныг тус тус **даргалсан** байна.

Хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **61**, шүүгч Д.Тунгалаг **69**, шүүгч А.Доржготов **47**, Р.Жамъянчойжил **36** тус тус оролцож, шүүгч Р.Жамъянчойжил **3** шүүх хуралдаан даргалсан байна.

Иргэний хэргийн танхимын шүүгчид Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **9**, шүүгч А.Доржготов **17**, Д.Тунгалаг **10**, Р.Жамъянчойжил нар тус бүр **9** тус тус оролцсон байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **25**, шүүгч Д.Тунгалаг **22**, А.Доржготов **21** удаа тус тус оролцжээ.

Иргэний хэргийн танхимаас 2005 онд Танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **883-ыг** гаргаснаас “гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” шүүгчийн **51** захирамж, “гомдол гаргаагүйд тооцох тухай” шүүгчийн **3** захирамж, “Улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” шүүгчийн **146** захирамж, “шүүх бүрэлдэхүүн томилох тухай” **668**, Танхимын тэргүүний захирамж, “харъяалал тогтоох тухай” Танхимын тэргүүний **3** захирамж тус тус гаргасан байна.

Улс төрийн намуудын тухай хуульд заасны дагуу “Монголын Социал Демократ Нам”, “Ард түмний нам”-ыг тус тус шинээр бүртгэж, “Монголын Ардчилсан Шинэ Социалист Нам” нэрээ өөрчилж, “Эх орон нам” болсныг, “Иргэний Зориг Бүгд Найрамдах Нам”, “Монгол Ардын Хувьсгалт Нам”, “Ардчилсан Нам”, “Монголын Уламжлалын Нэгдсэн Нам”-ууд дүрэмдээ өөрчлөлт оруулсныг тус тус улсын бүртгэлд бүртгэжээ.

Захиргааны хэргийн танхим

Захиргааны хэргийн танхим 2005 онд давж заалдах журмаар **170**, хяналтын журмаар **87**, бүгд **257** хэрэг хүлээн авчээ.

Давж заалдах журмаар ирүүлсэн **170** захиргааны хэргээс **155**-г нь захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэн, **9** хэргийг хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэж, одоо **6** хэргийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын журмаар ирүүлсэн **87** хэргийн **11** нь Ерөнхий шүүгчид, **76** нь шүүхийн шийдвэр, магадлалыг эс зөвшөөрч хяналтын журмаар гомдол гаргасан байв. Одоо **10** хэргийн үлдэгдэлтэйгээс **3** нь Ерөнхий шүүгчид гомдол гаргасан, **8** нь хяналтын журмаар хянагдах хэрэг юм.

Шүүгч П.Цэцгээ давж заалдах журмаар **54**, хяналтын журмаар **19** хэргийг хүлээж авснаас давж заалдах шатны шүүх хуралдаанаар **48**, хяналтын шатны шүүх хуралдаанаар **17**;

Шүүгч Д.Пунцаг давж заалдах журмаар **52**, хяналтын журмаар **25** хэргийг хүлээн авснаас давж заалдах шатны шүүх хуралдаанаар **49**, хяналтын шатны шүүх хуралдаанаар **22**;

Шүүгч Ч.Тунгалаг давж заалдах журмаар **44**, хяналтын журмаар **18** хэрэг хүлээн авснаас давж заалдах шатны шүүх хуралдаанаар **42**, хяналтын шатны шүүх хуралдаанаар **14**;

Шүүгч Л.Атарцэцэг давж заалдах журмаар **18**, хяналтын журмаар **12** хэрэг хүлээж авснаас давж заалдах шатны шүүх хуралдаанаар **16**, хяналтын шатны шүүх хуралдаанаар **5**;

Танхимын тэргүүн О.Зандраа давж заалдах журмаар **2**, хяналтын журмаар **9** хэрэг хүлээн авснаас, **5** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар тус тус илтгэж шийдвэрлүүлжээ.

2005 онд Захиргааны хэргийн танхим давж заалдах шатны шүүх хуралдааныг **38**, хяналтын шатны шүүх хуралдааныг 26 өдөр тус тус хийж, өдөрт дунджаар **4** хэрэг хэлэлцэн, нийт **218** хэргийг шийдвэрлэжээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа **61** удаа оролцсоноос **56**, шүүгч Д.Пунцаг **52** удаа оролцсоноос **1**, шүүгч П.Цэцгээ **43** удаа оролцсоноос **2**, хуралдааныг тус тус даргалж, шүүгч Ч.Тунгалаг **38**, Л.Атарцэцэг **22** удаа оролцсон байна.

Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх хуралдаанд шүүгч П.Цэцгээ **103** удаа оролцсоноос **43**, Ч.Тунгалаг **94** удаа оролцсоноос **52**, Д.Пунцаг **86** удаа оролцсоноос **37**, Л.Атарцэцэг **30** удаа оролцсоноос **13** хуралдааныг тус тус даргалжээ.

Ерөнхий шүүгчид гомдол гарган ирүүлсэн хэргүүдээс шүүгч Л.Атарцэцэг **4**, шүүгч Д.Пунцаг, П.Цэцгээ нар тус бүр **1**, хэргийг Ерөнхий шүүгчид танилцуулан өгч, шүүгч Ч.Тунгалаг **1** хэргийг Нийт шүүгчдийн хуралдаанаар илтгэж хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа **101**, шүүгч Ч.Тунгалаг **148**, Д.Пунцаг **112**, П.Цэцгээ **99**, Л.Атарцэцэг **51** удаа тус тус оролцож, Захиргааны хэргийн танхимын бүх шүүгч нар тус бүр **6** эрүүгийн хэргийг хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдаанд илтгэж, шийдвэрлүүлсэн байна. Мөн Танхимын тэргүүн О.Зандраа **9** шүүх хуралдааныг даргалжээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа **120** удаа оролцсоноос **50** хуралдааныг даргалж, шүүгч Л.Атарцэцэг **54**, Д.Пунцаг **59**, Ч.Тунгалаг **94**, П.Цэцгээ **66** удаа тус тус оролцжээ.

2005 онд Захиргааны хэргийн танхимаас шүүгчийн захирамж **6** гарснаас гомдол гаргаагүйд тооцох тухай **3**, гомдол хэлэлцүүлэхээс татгалзсан **1**, шүүх хуралдааныг хойшлуулах тухай **2** захирамж, шүүхийн тогтоол **16** гарснаас давж заалдах гомдлыг хэлэлцүүлэхгүй орхисон **4**, шүүх хуралдааныг хойшлуулах тухай **12** шүүхийн тогтоол тус тус гаргажээ. Танхимын тэргүүнээс нийт **250** захирамж гаргаснаас **228** нь шүүх бүрэлдэхүүнийг томилох тухай, **22** нь харьяалал тогтоох тухай захирамж байв.

Захиргааны хэргийн танхимд нийт **52** байгууллага, албан тушаалтнаас албан бичиг ирүүлснийг Танхимын тэргүүн **16**-д нь албан бичгээр, **36**-г нь утсаар болон зохих хэрэгт хавсаргах зэргээр шийдвэрлэж, **3** иргэний өргөдөлд албан бичгээр хариу өгчээ.

Хоёр. Шүүхийг мэргэжил, зохион байгуулалтын удирдлагаар хангах талаар

Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн арга зам нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нэгдсэн бодлого боловсруулж мөрдүүлэх, хуулиудыг нэг мөр ойлгон, зөв хэрэглэх талаар хуулийн албан ёсны тайлбар гаргах, шүүх, шүүгчдийн ажлыг шалган туслаж, тэдний дунд сургалт зохион байгуулах явдал юм.

Тайлангийн хугацаанд Улсын Дээд шүүхээс “Төрийн албаны тухай хууль”-ийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай, “Арбитрын тухай хууль”-ийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай, “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль”-ийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай зэрэг хуулийн тайлбар **3**-г гаргасан нь эдгээр хуулийг нэг мөр ойлгон зөв хэрэглэх, шүүхийн нэгдсэн практикийг тогтооход ач холбогдлоо өгнө гэж үзэж байна.

Баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох, цагдан хорих хугацааг сунгах ажиллагааны байдлыг 2002-2004 оны байдлаар судалж тойм, Гадаадын иргэдээс үйлдсэн гэмт хэрэгт оногдуулж байгаа ял шийтгэлийн байдлыг 2002-2004 оны байдлаар судалж тойм, шүүн таслах ажиллагаанд Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн алдаа, зөрчлийн шалтгааныг 2004 оны байдлаар судалж тойм, зөвлөмж гарган “Дээд шүүхийн Мэдээлэл” сэтгүүлд хэвлүүлжээ.

Улсын Дээд шүүх, Хууль зүйн Үндэсний төв, Япон улсын “Жайка”-гийн “Эрх зүйн шинэтгэл” төсөл хамтран “Иргэний хэргийн шийдвэрийн эмхтгэл”-ийн 1 дүгээр боть ном, Дэлхийн Банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт төсөлтэй хамтран “Захиргааны хэргийн шийдвэрийн эмхтгэл”-ийн 1, 2 дугаар товхимолыг тус тус хэвлүүлж, нийтийн хүртээл болголоо.

Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдаанаар Булган, Дорноговь, Дорнод, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн шүүх, тэдгээрийн харьяа сум дундын шүүхийн ажлыг шалган тусалсан тухай асуудлыг хэлэлцэн **тэмдэглэл 6**-г гарган холбогдох шүүхүүдэд нь хүргүүлжээ.

Гурав. Тамгын газрын ажлын талаар

Тамгын газар нь Шүүхийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гарсан дүрэм, журам, заавар, Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс өгсөн үүрэг, даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, шүүгч, ажилтнуудын хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэх талаар анхаарч ажиллаж иржээ.

Тамгын газрын даргын зөвлөл 26 удаа хуралдаж, уг зөвлөлийн хуралдаанаар Улсын Дээд шүүхийн 2004 оны жилийн эцсийн тооллогын дүн, тамгын газрын зарим ажилтнуудад цалинтай, цалингүй чөлөө олгох, цалинг нь урьдчилан олгох, эрүүл мэндийн болон амьдралын хүнд байдал, ар гэрт нь хөрөнгө мөнгөний гачигдал тохиолдсон ажилтнууд, ахмадын зөвлөлийн зарим гишүүдэд буцалтгүй тусламж олгох, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан, ажил

тасалсан зарим ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулах зэрэг нийт **30** асуудлыг хэлэлцэн, Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн **Тамгын газрын даргын тушаалаар** шийдвэрлэжээ.

Улсын Дээд шүүх энэ онд эрүүгийн **213**, иргэний **171**, захиргааны **2**, цагаатгалын **71**, тамгын газрын **10**, нийт **467** өргөдөл гомдол, **1699** албан бичиг, **1729** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу компьютерт бүртгэн, бүртгэл хяналтын карт нээн, Ерөнхий шүүгчид танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хувиарлан өгч шийдвэрлүүлсэнээс гадна **3119** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулсан байна.

Ерөнхий шүүгч **5** удаа иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллагын төлөөлөгч, нийт **26** хүнтэй биечлэн уулзаж санал хүсэлтийг нь сонсож, зохих хариуг өгчээ.

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба шүүх, шүүгчийн ажиллагаатай холбоотой **80** нийтлэл гарсныг бүртгэн, Ерөнхий шүүгчид тухай бүр нь танилцуулан холбогдох арга хэмжээг авахуулан үндэслэл муутай нийтлэлийг няцаах зорилгоор **58** хариу тайлбар, залруулгыг өдөр тутмын сонинуудад нийтлүүлжээ.

Байгууллагын номын санд **80** ширхэг номыг **985,8** төгрөгөөр худалдан авсны дотор Үндсэн хуулийн эрх зүйн **19**, Эрүүгийн эрх зүйн **20**, Иргэний эрх зүйн **17**, Захиргааны эрх зүйн **17**, Хөдөлмөрийн эрх зүйн **5**, Олон Улсын эрх зүйн **2**, Төр эрх зүйн **31** болон бусад **41** ширхэг номыг ашиглаж байна.

Түүнээс гадна **33** нэрийн **157** ширхэг ном шинээр бүртгэсний **15** нэрийн **67** ширхэг номыг “Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг”, “Соросын сан”, “Ханнс-Зайделийн сан”, “Хүний Эрхийн Үндэсний комисс”, “Албадан ажил хийлгэх, ял эдлүүлэх ажиллагааг хэвшүүлэх” төслөөс бэлэглэлээр авчээ.

Архив харуцсан мэргэжилтэн нь 2004 оны баримтуудыг Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхим, Тамгын газар, Шүүхийн судалгааны төвөөс 2005 оны 1 дүгээр улиралд багтаан хүлээн авч, “Байнгын хадгалах бүртгэл”-ийн дансанд **54**, “Түр хадгалагдах бүртгэл”-ийн дансанд **34** нэгж болгон зохих дансуудад бүртгэн хайрцагласан байна.

Байнга хадгалагдах нэгжийн бүртгэлийн дансыг 1949-1973 он, 1974-1995 он, 1996-2004 он гэж 3 ангилан, 1949-1973 он дуусталх **87** нэгжийг Үндэсний Архивын газар хүлээлгэн өгчээ.

Тамгын газрын даргын тушаалаар “Улсын Дээд шүүхийн шүүгчид Төрийн холбооны гар утас хэрэглэх журам”, “Улсын Дээд шүүхэд автомашин хэрэглэх журам”, “Халамжийн сан бүрдүүлэх, хадгалах, зарцуулах журам”, “Улсын Дээд шүүхийн автомашинд эвдрэл гарсан үед үзлэг хийж акт тогтоох, автомашин хүлээлцүүлэх үүрэг бүхий байнгын комиссын бүрэлдэхүүн”-ыг шинэчлэн баталлаа.

Тайлангийн хугацаанд иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Г.Буяннэмэх, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах Б.Зориг нар Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 53 дугаар зарлигаар Нийслэлийн Баянгол, Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилогдон ажиллаж байна.

Шүүгчийн албан тушаалд дэвшин томилогдсон дээрх ажилтнууд болон өөрсдөө хүсэлт гаргасан зарим ажилтнуудыг эрхэлж байсан ажил, албан тушаалаас нь чөлөөлж, И.Ганбатыг Ерөнхий шүүгчийн туслах-шинжээчийн, С.Соёмбо-Эрдэнийг Нийт шүүгчдийн хуралдааны зохион байгуулалтын асуудал хариуцсан шинжээчийн, Н.Батзоригийг Иргэний хэргийн танхимын тэргүүний туслах-шинжээчийн, Ц.Сайхантуяаг захиргааны хэргийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээчийн, Ж.Эрдэнэчимэгийг Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээчийн, Р.Ичинхорлоог Иргэний хэргийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээчийн, Б.Мөнхзулыг Захиргааны хэргийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээчийн, А.Эрдэнэцэцэгийг Санхүү, хангамж хариуцсан ахлах зааварлагч-нягтлан бодогчийн албан тушаалд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар томилон ажиллуулж байна.

Төрийн захиргааны албанд түр хугацаагаар томилогдон ажиллаж байсан зарим ажилтныг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалтанд

оруулж, уг шалгалтанд тэнцсэн Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Ж.Халиун, Захиргааны хэргийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Б.Мөнхзул, Санхүү, Хангамж хариуцсан ахлах зааварлагч-нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, Мэдээлэл, лавлагааны ажил хариуцсан мэргэжилтэн Б.Мягмаржав, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Д.Алтанжигүүр нарыг **төрийн захиргааны албан хаагчийн тангараг** өргүүлээ.

Шинээр томилогдон ажиллаж байгаа захиргааны ажилтнуудад **“Баримт бичгийн стандарт эмхтгэл”** номыг хувилж болон ажилд нь өдөр тутам хэрэглэгдэх хууль, хуулийн тайлбар, зөвлөмж, тойм, журам зэрэг гарын авлага бэлтгэн тараан өгчээ.

Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу Б.Дангаасүрэнг Шүүхийн судалгааны төвийн захиралын, Н.Төрбатыг Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга-шүүн таслах ажиллагаа эрхэлсэн зөвлөхийн, М.Дамирансүрэнг Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны даргын албан тушаалд Төрийн албаны зөвлөлөөр “Дүгнэлт” гаргуулан томиллоо.

“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасан болзлыг хангасан Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Л.Ганзориг, Б.Чимгээ, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч С.Мөнхжаргал нарт “Ахлах түшмэл” ангиллын “АА-8” зэрэглэлийн **“Дөтгөөр”** зэрэг дэвийг олгожээ.

“Төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д заасан болзлыг хангасан Хангамжийн асуудал хариуцсан менежер-референт С.Баасанцэрэн, Нийт шүүгчдийн хуралдааны зохион байгуулалтын асуудал хариуцсан шинжээч С.Соёмбо-Эрдэнэ, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Б.Чимгээ, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч С.Мөнхжаргал, Эрүүгийн хэргийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч С.Одгариг, Санхүү, Хангамж хариуцсан ахлах зааварлагч-нягтлан бодогч Б.Хишигсүрэн нарын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тус бүр **5** хувиар нэмэгдүүлжээ.

“Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хууль, “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн төвшин, төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнэх журам”-д заасны дагуу Улсын Дээд шүүхийн төрийн захиргааны албан хаагчидтай 2005 онд байгуулсан **“Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ”**-г үнэлж дүгнэхэд, **52** ажилтан хамрагдсанаас **41** нь **“А”**, **9** нь **“В”**, **2** нь **“С”** үнэлгээ авсан нь ажилтнуудын ажиллах ур чадвар хэвийн байгааг харуулж байгаа нэг үзүүлэлт юм.

“Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ”-г үнэлж дүгнүүлэн А. В, С үнэлгээ авсан төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад **8,370,9** мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олголоо.

Клинкийн Нэгдсэн 2 дугаар эмнэлэг болон Төрийн Тусгай албан хаагчдын Нэгдсэн эмнэлэгээр 2005 онд үйлчлүүлэх шүүгч, ажилтнууд, тэдний эхнэр, нөхөр, ам бүлд байгаа хүүхдүүдийн судалгааг хавсралтаар гарган дээрхи эмнэлгүүдийн захиргаанд хүргүүлж, тэднийг байнгын эмчийн хяналт, эмнэлгийн урьдчилсан үзлэгт хамруулах, шаардлагатай тохиолдолд хэвтэн эмчлүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэн өглөө.

Клинкийн Нэгдсэн 2 дугаар эмнэлэгийн чих, хамар хоолой, нүд, зүрх судас, мэдрэл зэрэг нарийн мэргэжлийн эмч нарыг өөрийн шүүх дээр авчран бүх шүүгчдийг эмнэлэгийн үзлэгт хамрууллаа.

Шүүгч, ажилтнуудын гэр бүлээс их, дээд сургуульд 2005-2006 оны хичээлийн жилд суралцаж байгаа **5** оюутны “Сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэх тухай” гэрээг Сургалтын төрийн сантай байгууллаа.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу ээлжийн амралтаараа өөрийн төрсөн нутаг очиж амарсан **9** шүүгч, ажилтанд очих, ирэх унааны зардалд **179,6**, ар гэрт нь гачигдал тохиолдсон **16** шүүгч, ажилтан, Ахмадын зөвлөлийн зарим гишүүн, өндөр настнуудад нийт **1,011,4** мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар тус тус олгов.

Дэлхийн банкны санхүүжилттэй “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн санхүүгийн дэмжлэг туслалцаатайгаар Эрүү, Захиргааны хэргийн танхимын тэргүүний болон Захиргааны хэргийн танхимын туслахуудын өрөөнд **12,381,6** мянган төгрөгийн тавилга, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдааны танхимд **12,708,2** мянган төгрөгийн сервер, зурагт, хувилагч машин, гар утасны долгион саармагжуулагч, **8,300,4** мянган төгрөгийн архивын иж бүрэн тавилга зэрэг эд хөрөнгийг шинээр авчээ.

Төрийн өмчийн хорооны 2005 оны 175 дугаар тогтоолоор Захиргааны хэргийн танхимын тэргүүнд Иргэний Нисэхийн удирдах газраас **16,660,0** мянган төгрөгийн үнэ бүхий “Соната-5” маркийн автомашиныг балансаас балансад шилжүүлэн авч, мөн оны 94 дүгээр тогтоолын дагуу илүүдэлтэй байгаа **7,652,4** мянган төгрөгийн үнэ бүхий тавилга, эд хогшлийг Дорноговь, Дундговь, Нийслэл, дүүргийн шүүхэд балансаас балансад шилжүүлэн өгсөн байна.

Улсын Дээд шүүх, Нийслэл, дүүрэг, Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн дунд зохион явагддаг “Шилжин явах цом”-ын төлөө спортын тэмцээнд манай баг, тамирчид амжилттай оролцож, багийн дүнгээр **хоёрдугаар** байр эзлэв.

Мөн хуулийн төв байгууллагуудын дунд жил бүр уламжлал болон зохиогддог “Шилжин явах цомын төлөө спортын тэмцээн”-д манай баг тамирчид амжилттай оролцож, багаараа **тэргүүн** байр эзэлж, “Шилжин явах цом” хүртлээ.

2005 онд Улсын Дээд шүүхэд нийт **260.5** сая төгрөг үүнээс урсгал зардалд **240.5** сая төгрөг, их засварт **10.0** сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад **10.0** сая төгрөг тус тус батлагдсан билээ.

Урсгал зардлын батлагдсан төсвийг бүрэн авч, төсөвт тусган төсвийн зардлыг зохих журмын дагуу зарцуулж, санхүүгийн мэдээ тайланг хугацаанд нь гаргаж ирлээ.

Урсгал зардлын төсвийг хэрхэн зарцуулсныг зүйл тус бүрээр нь танилцуулбал:

- Бичиг хэрэг, аж ахуйн зардалд **6964.3** мянган төгрөг төлөвлөснөөс **8763.9** мянган төгрөг зарцуулагдсан бөгөөд **1799.6** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Гэрэл цахилгааны зардалд **2883.7** мянган төгрөг төлөвлөснөөс **4311.2** мянган төгрөг зарцуулагдаж, **1427.5** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Түлш, халаалтын зардалд **15494.00** мянган төгрөг төлөвлөснөөс **13164.2** мянган төгрөг зарцуулагдаж, **2.329.8** мянган төгрөгөөр **хэмнэгдсэн**;
- Тээвэр, шатахууны зардалд **10110.1** мянган төгрөг төлөвлөснөөс **10414.8** мянган төгрөг зарцуулж, **304.7** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Шуудан, холбооны зардалд **14651.8** мянган төгрөг төлөвлөснөөс **11265.3** мянган төгрөг зарцуулагдаж, **3386.5** мянган төгрөгөөр **хэмнэсэн**,
- Цэвэр, бохир усны зардалд **1173.9** мянган төгрөг төлөвлөснөөс **683.3** мянган төгрөг зарцуулагдаж, **490.6** мянган төгрөг **хэмнэгдсэн**;
- Дотоод албан томилолтын зардалд **3458.0** мянган төгрөг төлөвлөснөөс **3605.0** мянган төгрөг зарцуулагдаж, **147.0** мянган төгрөгөөр **хэтэрсэн**,
- Гадаад албан томилолтын зардалд **5.320.0** мянган төгрөг төлөвлөснөөс **5357.4** мянган төгрөг зарцуулагдаж, **37.4** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Ном, хэвлэл авах зардалд **1011.6** мянган төгрөг төлөвлөснөөс **1143.3** мянган төгрөг зарцуулагдаж, **131.7** мянган төгрөгөөр **хэтэрсэн**,
- Нормын хувцас авах зардалд **127.5** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **141.4** мянган төгрөг зарцуулж **13.9** мянган төгрөг хэтэрсэн,
- Урсгал засварын зардалд **1833.3** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **5092.7** мянган төгрөг зарцуулагдаж, **3259.4** мянган төгрөгөөр **хэтэрсэн**,
- Гадаад зочны зардалд **5.100.0** мянган төгрөг төлөвлөснөөс **4498.0** мянган төгрөг зарцуулж **602.0** мянган төгрөг хэмнэгдсэн
- Ерөнхий шүүгчийн байрны зардалд **303.2** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **238.6** мянган төгрөг зарцуулагдаж, **64.6** мянган төгрөгөөр **хэмнэгдсэн**;

- Буцалтгүй тусламж, тэтгэлэг урамшууллын зардалд **6.500.3** мянган төгрөг төлөвлөснөөс **7458.28** мянган төгрөг зарцуулагдаж, **957.98** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Төлбөр хураамж болон бусад зардалд **1244.4** мянган төгрөг төлөвлөгдснөөс **870.7** мянган төгрөг зарцуулж **373.7 мянган төгрөг хэмнэсэн**,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд **31375.5** мянган төгрөг төлөвлөснөөс **29606.2** мянган төгрөг зарцуулагдаж, **1769.3** мянган төгрөгөөр **хэмнэгдсэн**;
- Цалин хөлс, нэмэгдлийн зардалд **118846.0** мянган төгрөг төлөвлөгдснөөс **105750.2** мянган төгрөг зарцуулагдаж, **13095.8** мянган төгрөг **хэмнэгдсэн** .
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд **12660.0** мянган төгрөг батлагдсанаас 12660.0 мянган төгрөг ,
- Жижиг эд хогшил худалдан авах зардалд **1000.0** мянган төгрөг батлагдсанаас **960.9** мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

2005 онд конторын зарим өрөөнүүдийг түрээслэн нийт **6.075.500** төгрөгийн орлого орсноос “Шинэ жил”, “Цагаан сар”, “Эмэгтэйчүүдийн баяр”, “Хүүхдийн баяр”, “Ахмадын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд, мөн шүүгч, ажилтнуудыг амраах, Хэвлэл мэдээллийн төвийн болон Архивын өрөөний засварт болон төсвийн зардал хүрэлцдэггүй бусад зардалд зарцуулж, үлдэгдэл мөнгөгүй болсон байна. Түрээсийн орлогыг хэрхэн зарцуулсан талаархи тодорхой мэдээллийг Тамгын газрын тайлангаас үзэж болно.

Ийнхүү 2005 онд байгууллагаа тохижуулах, шүүгч, ажилтнуудын ая тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх, тавилга, техник тоног төхөөрөмжийг шинэчлэхэд ихээхэн анхаарч ажиллаа.

Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх **10.0** сая төгрөгийн өртөгтэй засварын ажлыг “БЭСТ-БРИКЕТ” ХХК-иар гүйцэтгүүлж, 1 баруун, зүүн жигүүрийн 1-4 дүгээр давхрын шатыг боржин чулуугаар өнгөлж, шатны бариулыг зэвэрдэггүй ган төмрөөр солилоо.

Түүнчлэн **4,797,0** төгрөгийн үнэ бүхий Төрийн холбооны гар утсыг бүх шүүгчдэд, шүүгч, ажилтнуудын үйлчилгээнд зориулж **9,750,0** төгрөгийн үнэтэй “Делика” бага оврын автобус худалдан авсан байна.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын тушаалаар байгуулагдсан **тооллогын комисс** нь **14** хоногийн хугацаанд байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг шүүгч, ажилтнуудын эзэмшиж байгаа эд хөрөнгө, шүүх хуралдааны танхим, коридор, вестибюльд байгаа эд зүйлсийг хариуцсан үйлчлэгчдийн карттай нь, агуулахад хадгалагдаж байгаа эд зүйлсийг үлдэгдлээр нь менежер–нягтлан бодогчийн бүртгэлтэй тулган тоолсон байна.

Байгууллагын дүнгээр **363,583,6** мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, **5,524,3** мянган төгрөгийн үнэ бүхий **бичиг хэрэг, аж ахуйн материал, 147,107,8** мянган төгрөгийн үнэ бүхий **7 автомашин** тоологдлоо.

Дөрөв. Шүүхийн судалгааны төвийн ажлын талаар

Улсын Дээд шүүхийн дэргэдэх шүүхийн Судалгааны төв нь эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажилгааны үзүүлэлтүүдийг жил, хагас жил, улиралаар гаргаж, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүнүүдэд тухай бүр танилцуулж, Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актыг шүүхийн нэгдсэн санд оруулах, нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр хийх, шүүн таслах ажлын зарим тулгамдсан асуудлаар тойм, зөвлөмж гаргах зэрэг үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг шүүхээс олгож байгаа байдлыг 2004 оноор судалж Дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхимтай хамтарч тойм боловсруулан нийт шүүхүүдэд хүргүүлжээ.

Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаар 2005 онд хянан хэлэлцэгдсэн хэргүүдийн шийдвэр, магадлалуудыг болон “Тусгай зөвшөөрөл” олгохтой холбоотой асуудлыг судалж тухайн танхимд нь танилцуулсан байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл заалтыг хэрхэн ойлгож хэрэглэж байгаа талаар Нийслэл, Аймгийн Захиргааны хэргийн шүүхүүдсээс товч судалгаа авч Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимтай хамтарч зөвлөмж боловсруулахад оролцжээ.

Шинээр батлагдсан “Иргэний хууль”-ийг дагаж мөрдсөн үеэс буюу 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс эдийн бус гэм хорыг арилгахтай холбогдсон хэргийг шийдвэрлэсэн байдлыг судлан үзэж дүнг иргэний хэргийн танхимд танилцуулжээ.

Мөн 2002-2005 оны байдлаар улсын тэмдэгтийн хураамжаас ямар үндэслэлээр чөлөөлж байгааг шүүхүүдээр нь судлан үзэж дүнг захиргааны хэргийн танхимд танилцуулсан байна.

Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн алдаа, зөрчлийг 2004 оны байдлаар судлан үзэж Улсын Дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхимд дүнг танилцуулжээ.

Шүүхээс Захиргааны хариуцлагын тухай хуулийг хэрэглэх явцад гарч байгаа хүндрэл бэрхшээлийг судалж Хууль Зүй, дотоод хэргийн яаманд санал хүргүүлжээ.

Мөн 2004, 2005 оны хагас жилийн байдлаар “Гадаадад гаргана” гэсэн зараар бусдыг залилан мэхлэж, ял шийтгүүлсэн хүмүүсийн судалгааг гаргаж, Гадаад хэргийн яаманд хүргүүлсэн байна.

Шүүхийн мэдээлэлийн нэгдсэн санд 2005 онд шинээр батлан гаргасан хууль **7**, олон улсын гэрээ **14**, хуулийн нэмэлт өөрчлөлт **101**, Улсын Их Хурлын тогтоол **73**, Засгийн газрын тогтоол **4**, Ерөнхийлөгчийн зарлиг **30**, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн хэм хэмжээ тогтоосон захирамж **14**, тойм, зөвлөмж **1**, шүүн таслах ажлын практик тогтоосон эрүүгийн **67**, иргэний **84**, захиргааны **8**, Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны **26** тогтоол, шийдвэрийг оруулжээ.

Монгол Улсын төр захиргааны төв байгууллагын болон бүх шатны шүүхийн удирдлагыг шүүн таслах ажлын зохих мэдээлэлээр хангахын тулд тодорхой судалгаа танилцуулгыг гаргаж ажиллав. Энэ зорилгоор 2004 оны бүтэн жил, 2005 оны эхний хагас жилийн байдлаар шүүн таслах ажлын нэгдсэн дүн, мэдээг гаргаж товч танилцуулгын хамт Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Дээд шүүхийн удирдлага, бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч нарт хүргүүлж, мэдээллийг “Өдрийн сонин”-д нийтлүүлжээ.

Улсын Ерөнхий Прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Хүний эрхийн үндэсний комиссын хүсэлтээр 2001-2004 онд шүүхээс торгох, баривчлах ял шийтгэсэн байдал, 2002-2004 онд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын ажилтнуудаас албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн, урвуулсан хэрэгт ял шийтгүүлэгчдийн судалгаа, 2003-2004 онд ял шийтгүүлсэн эмэгтэйчүүд, 2004 онд хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрсэн, гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн судалгааг нэгтгэн гаргаж хүргүүлсэн байна.

Түүнчлэн 1926 оноос хойш 80 жилийн хугацаанд шүүхээр цаазаар авах ял шийтгүүлэгчдийн тоон үзүүлэлт, 2002 оны 9 дүгээр сараас эрүү, иргэний хэрэг, 2004 оны 6 дугаар сараас захиргааны хэрэг хянан шийдвэрлэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг үндэслэсэн шүүхийн шийдвэр тогтоолуудыг Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхэд судлан дүгнэлт гаргажээ.

Дэлхийн банкны “Шүүх эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд хэрэгжиж байгаа хууль зүйн мэдээлэлийн нэгдсэн сүлжээнд шүүхийн статистик тоон мэдээллээс оруулах мэдээлэлийн хувилбарыг боловсруулж, програмын ажлын хэсэгт хүргүүлэв.

Шүүхийн статистик мэдээний үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох үүднээс 11 мэдээний маягыг шинэчлэн боловсруулж Үндэсний статистикийн газарт хянуулан зөвшөөрөл авч, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, мөрдөж эхлэв.

“Монголын төр эрх зүй”, “Дээд шүүхийн мэдээлэл” сэтгүүлийн тус бүр **4** дугаарын нийтлэлийн материалыг захиалан бэлтгүүлж, Улсын Дээд шүүхээс гаргасан тайлбар, зөвлөмж, тойм шүүхийн практик тогтоосон шийдвэр тогтоолуудыг бэлтгэн гаргажээ.

Тав. Гадаад арга хэмжээ, сургалт, семинарын талаар

Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, шүүгчийн туслахууд болон Тамгын газрын ажилтнууд 2005 онд гадаад болон дотоодод болсон сургалт, семинаруудад идэвхтэй оролцлоо.

Тайлангийн хугацаанд шүүгч Д.Тунгалаг АНУ-ын Техас муж улсын Уэслианы Их сургуулиас зохион байгуулсан сургалтад оролцжээ.

Мөн шүүгч Л.Атарцэцэг, Ч.Тунгалаг, Д.Пунцаг, Ерөнхий шүүгчийн туслах Б.Цогт нар ХБНГУ-ын Бавари муж улсын Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлаад ирлээ.

Түүнчлэн шүүгч Ч.Ганбат Австрали улсын Күислэнд мужийн Брисбэн хотноо 2005 оны 3 дугаар сарын 18-27-ны хооронд зохион байгуулагдсан “Ази, Номхон далайн орнуудын Ерөнхий шүүгч нарын 11 дүгээр бага хурал”-д оролцсон байна.

Дээрхээс гадна шүүгч А.Доржготов, Д.Пунцаг нар Швед улсын Стокгольм хотноо “Арбитрын сургагч багш бэлтгэх сургалт”, шүүгч Ч.Ганбат АНУ-ын Техас муж улсын Уэлианы Их сургуулийн Азийн сургуулийн “Toback & Associates” сургалтад, шүүгч Ч.Ганбат, А.Доржготов, Б.Доржготов, Д.Пунцаг нар БНХАУ-ын Ардын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Шао Янын урилгаар Бээжин, Шанхай хотуудад “Дэлхийн хуульчдын холбооны 22 дугаар Их хурал”-д, шүүгч А.Доржготов Япон улсын Нагоя хотноо зохион байгуулагдсан “Монголын нүүдэлчин нийгэм ба газар өмчлөл-шилжилтийн үеийн улс орнуудын газар хувьчлал” сэдэвт симпозиумд, Танхимын тэргүүн Д.Батсайхан Филиппин улсын Манила хотноо “Шүүхийн шинэчлэл” сэдэвт олон улсын бага хуралд, Танхимын тэргүүн О.Зандраа Энэтхэг улсын Лакнау хотноо зохионы байгуулагдсан “Дэлхий дахины Ерөнхий шүүгчдийн Олон улсын 6 дугаар бага хурал”-д тус тус оролцлоо.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч асан Ч.Ганбатын урилгаар АНУ-ын Техас муж улсын Уэслианы Их сургуулийн профессор, Азийн дээд сургуулийн захирал, ноён Жой Спурлок II манай оронд айлчилж, Улсын Дээд шүүх, Нийслэл, Нийслэлийн захиргааны хэргийн болон Дорноговь, Орхон аймгийн шүүхийн шүүгчидтэй уулзан, эдгээр шүүхүүдийн ажил байдалтай танилцлаа.

Ирж буй 2006 онд зарим шүүгчид АНУ-ын Техас муж улсын Уэслины Их сургуульд болон БНСУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүгчдийн сургалтын төвд зохион байгуулагдах уламжлалт сургалтад, Захиргааны шүүхийн шүүгчид ХБНГУ-д зохин байгуулагдах шүүгчдийн сургалтад тус тус оролцоно.

Мөн 2006 онд шүүгчдийг өөр бусад шугамаар гадаад сургалтад хамруулах асуудлыг судлаж байна.

Эрхэм шүүгч, ажилтнуудаа!

Тайлангийн хугацаанд идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан Шүүгч А.Доржготов, Б.Доржготов, С.Нямжав, Д.Тунгалаг, Хангамжийн асуудал хариуцсан менежер С.Баасанцэрэн, Компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан мэргэжилтэн Д.Мөнхзориг, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Т.Өсөхбаяр, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Э.Амин-Эрдэнэ, Ц.Оч, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч С.Мөнхжаргал, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Д.Алтанжигүүр, жолооч Г.Батчулуун, сантехникийн слесарь бөгөөд цахилгаанчин Б.Ширэндэв, үйлчлэгч Л.Даваажав, Д.Оюунцэцэг, Ц.Цэцэгсүрэн нарт хамт олныхоо нэрийн өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлж, цаашдын ажил хөдөлмөрт нь өндөр амжилт хүсэн ерөөе!

Эрхэм шүүгчид, албан хаагчид аа!

Улирч буй 2005 онд бид багагүй зүйл хийж амжуулсан ч шинэ 2006 онд түүнээс ч их зүйл хийх шаардлагатай байна.

Улсын Дээд шүүх 2006 онд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

1. “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”, “Шүүхийн менежментийг бололвсронгуй болгох үзэл баримтлал”-ыг тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх;

2. Шүүхийн шинэчлэлийг улам гүнзгийрүүлэх, эрчимжүүлэхийн тулд гадны төслийн байгууллагууд болон эрдэмтэд, судлаачид төр засгийн байгууллага, албан тушаалтнууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах;

3. Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон Шүүхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судлаж шийдвэрлэх;

4. Шүүгч нарын ажлын ачааллыг бууруулж, тэднийг анхан болон давж заалдах шатны шүүхүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах, хуулийн албан ёсны болон шинжлэх ухааны тайлбар гаргах нөхцөл боломжийг бүрдүүлэх;

5. Иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг үргэлжлүүлэн, эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр товхимол ном болгон гаргах;

6. Шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй болгох зорилгоор “Шүүхийн мэдээллийн систем”-ийн нэгдсэн сүлжээг бий болгож, интернэтэд байршуулах ажлыг Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөлтэй хамтран хэрэгжүүлэх;

7. Шүүгч, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд тэдгээрийг худалдан авах урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулах;

8. Шүүх байгуулагдсаны 80 жилийн тэмдэглэх ажлыг зохион байгуулах;

9. Улсын Дээд шүүхийн конторын барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгэх;

Эдгээр бүх зорилтыг шийдвэрлэхийн төлөө хамтран ажиллацгаая.

Та бүхний цаашдын ажилд амжилт хүсье.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА